



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 679

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлж,
нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчит хуулийн этгээдээс татан төвлөрүүлсэн ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 220,749,996.18 (хоёр зуун хорин сая долоон зуун дөчин есөн мянга есөн зуун ерэн зургаан төгрөг арван найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, 201,488,943.66 (хоёр зуун нэг сая дөрвөн зуун наян найман мянга есөн зуун дөчин гурван төгрөг жаран зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 12 ширхэг автомашиныг "Засгийн газрын автобааз" төрийн өмчит үйлдвэрийн газарт шилжүүлж, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Засгийн газрын автобаазын захирал Г.Чинзориг, тогтоолын хавсралтад заасан төрийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх, үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу үйлдвэрийн газрын дансанд төвлөрүүлэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, худалдсаны дараа хасуулах, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

123006907
34-r_huraldaan.docx

2.4.Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 452 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12- дугаар сарын 12- ны өдрийн
679 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИТ ЗАРИМ БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АВТОМАШИНУУДЫГ "ЗАСГИЙН ГАЗРЫН АВТОБААЗ" ТӨҮГ-Т ШИЛЖҮҮЛЖ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Хуулийн этгээдийн нэр	Автомашинны нэр, марк, улсын дугаар	Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын нийт үнэ, (төгрөг)	Хуриутлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Монголпросветмет ТӨҮГ Бор-Өндөр УБҮ	Тоёота Ландкрузер-105 6878 УБС	JTECJ09J505506606	2002/2007	35,000,000.00	35,000,000.00	-	8,000,000.00
2	Соёлын өвийн үндэсний төв	Тоёота Ландкрузер-100 2241УНИ	UZJ1000021219	1998/2006	18,500,000.00	9,712,500.00	8,787,500.00	8,800,000.00
3	Татварын ерөнхий газар	Тоёота Вохи 0296УБҮ	AZR600045172	2002/2010	12,300,000.00	12,300,000.00	-	4,000,000.00
4	ШУА-ын Одон орон геофизикийн хүрээлэн	Ландкрузер Прадо-J90 7863УБХ	JTB11UJ94X0019592	1998/1999	2,400,000.00	2,000,000.00	400,000.00	4,000,000.00
5	Стандарт хэмжил зүйн газар	Ниссан алтима 0296УНГ	1N4AL11D64C121726	2004/2010	6,746,666.66	6,746,666.66	-	1,500,000.00
6	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар	Ниссан теана 0482УБ3	JN1BAUJ32Z0000116	2008/2008	22,357,530.00	14,283,977.50	8,073,552.50	8,100,000.00
7	Боловсролын ерөнхий газар ТБАГ	Ниссан Теана 0969УНТ	LGBF1AE037R007674	2007/2007	44,391,653.00	44,391,653.00	-	2,500,000.00
8	Хууль зүйн туслалцааны төв	Хьюндай элентра 0154УБ3	KMHU41BP8U544027	2008/2008	20,425,531.92	20,425,531.92	-	1,500,000.00

9	Авто Тээврийн Үндэсний Төв	Ниссан Теана 0578УНУ	LGBF1AE018R01 3538	2007/2008	6,000,000.00	3,999,999.98	2,000,000.02	2,500,000.00
10	Мэдээлэл холбоо сүлжээ	Тоёота Гранд Марк- 2 6399УБВ	GX1006000810	2000/2007	15,313,414.60	15,313,414.60	-	2,000,000.00
11	Төрийн банк	Тоёота Гранд Марк- 2 0477УАВ	GX1106017370	2001/2010	12,300,000.00	12,300,000.00	-	2,000,000.00
12	Төрийн тусгай хамгаалалтын газар	Хьюндай Соната-5 4419УНУ	KMHM41BP4A1 40068	2004/2004	25,015,200.00	25,015,200.00	-	1,000,000.00
Нийт дүн					220,749,996.18	201,488,943.66	19,261,052.52	45,900,000.00
					(хоёр зуун хорин сая долоон зуун дөчин есөн мянга есөн зуун ерэн зургаан төгрөг арван найман мөнгө)	(хоёр зуун нэг сая дөрвөн зуун наян найман мянга есөн зуун дөчин гурван төгрөг жаран зургаан мөнгө)	(арван есөн сая хоёр зуун жаран нэгэн мянга тавин хоёр төгрөг тавин хоёр мөнгө)	(дөчин таван сая есөн зуун мянган төгрөг)